3.1.1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдал, экологи, орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар хийсэн.

Шууд нөлөөлөл – Нийт 15 үзүүлэлтээс 13 нь буюу 86,6 хувь нь шууд хэлбэрийн үйлчлэлд өртөхөөр байна. Өөрөөр хэлбэл энэ нь үйлчлэлийн эрчим нь их байх магадлалыг ихэсгэж байна. Төсөл хэрэгжүүлэгч төслийнхөө үйл ажиллагааны химийн бодисын хадгалалтаас үүсэх эрсдэл, ахуйн хатуу хог хаягдал нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөллүүд гарах боловч төслийг дагалдан үүсэх орлогууд болон улс, орон нутгийн орлого нэмэгдэх зэрэг эерэг нөлөөллүүд гарах юм.

Шууд бус нөлөөлөл – Нийт 2 нь шууд бус нөлөөлөл байгаа бөгөөд 13,3 хувийг эзлэж байна. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хөрсний элэгдэл, эвдрэл, агаарын чанарт үзүүлэх нөлөө зэрэг нөлөөллүүд хамрагдана.

Урт хугацааны нөлөөлөл – нь 3 буюу 20 хувийг эзлэж байна. Байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөлөл гарч болзошгүй бөгөөд эдгээр нь эргэж сэргэхдээ ихээхэн хугацаа шаарддаг.

Богино хугацааны нөлөөлөл – Үйлчлэлийн хугацааны хувьд 12-н үйлчлэл байгаа буюу 80 хувийг эзлэж байна. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх дуу шуугианы нөлөө, машин механизмын үйлчлэлээр байгаль орчин нөлөөлөх нөлөөлөл бий болох гэх мэт. Богино хугацааны сөрөг нөлөөллүүдийг бууруулахад чиглэсэн менежментийг зохистой болгох шаардлагатай. Үүний зэрэгцээ хувийн секторын болон татварын орлого нэмэгдэх, түүнчлэн орон нутгийн төсвийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэг үзүүлэлтүүд нь богино хугацааны эерэг нөлөөлөлд орж байна.

Хүчтэй нөлөөлөл – Болгоомжгүйгээс гал түймэр гарах, хүчтэй буюу аадар борооны улмаас үерт өртөх гэсэн 5 хүчтэй нөлөөлөл байгаа бөгөөд үйлчлэлийн эрчмийн 33,3 хувийг эзлэж байна. Зарим нэг хүчтэй нөлөөлөл нь ажилчдын болон зохион байгуулалтын болгоомжгүй үйлдлээс болж гарч болзошгүй юм.

Дунд зэргийн нөлөөлөл – нь 4 буюу үйлчлэлийн эрчмийн 26,6 хувийг эзлэж байна. Төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудлаар ахуйн болон агуулахын хатуу хаягдал үүсэх зэрэг асуудлууд орно.

Сулавтар буюу бага эрчимтэй нөлөөлөл – нь 6 буюу үйлчлэлийн эрчмийн 40 хувийг эзлэж байна. Төслийн тоног төхөөрөмжийн чимээ шуугианы нөлөөлөл нь орчинд нөлөөлөх, хатуу хог хаягдал ихсэх зэрэг асуудлууд орж байна.

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзэхэд “Сика монголиа” ХХК-ийн Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт хэрэгжих Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийг хэрэгжүүлэх үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг агаар, хөрс, ургамал, газрын доорх ус зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн хөрсийг бохирдол, элэгдлээс хамгаалах, агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах, хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг үнэлгээ хийсэн компаний зүгээс өгсөн зөвлөмжийн дагуу тухай бүрд нь хэрэгжүүлэх замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулбал эерэг тал нь илүү болох юм.

3.1.2. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн байршлын сонголтыг оновчтой хийсэн гэж үзэж болно. Учир нь энэхүү объект нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт, 14038м² талбайд үйл ажиллагаа явуулна.

“Сика монголиа” ХХК-ийн төслийн байршил, шийдэл, төлөвлөлттэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалтыг хүснэгтэд үзүүлээ. Уг объектын байршлын улмаас хүн ам, хүрээлэн буй орчинд төслийн үйл ажилгаанаас үзүүлж буй нөлөөллийн радиус харьцангуй бага юм. Нөлөөллийн нийт 18 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 10 зүйлд нөлөөлөлгүй байна. Нөлөөллийн зэрэглэлээр үзэхэд 2 нь бага, 5 нь дунд ба 1 нь их нөлөөлөлтэй байна. Иймд тухайн төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөлөл байхгүй гэж үзэж болно.

3.2. Гол сөрөг нөлөөлөл

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс үзвэл төслийн үйл ажиллагааны явцад газрын гадаргуу, хөрс, агаар бохирдох зэрэг нөлөөллүүд нь аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлаагүйгээс үүсэх нөлөөллүүд байна.

Голлох нөлөөллийг тодорхойлохдоо:

1. Гарч болох бохирдлын түвшинг харгалзан үзэх
2. Сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг эрж хайхад шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх
3. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар зөвлөмж боловсруулж өгөх явдал юм.

Энэ зорилгоор байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон тээвэрлэлтийн үе шатууд дахь нөлөөллийн эрчмийг үнэлсэн экспертүүдийн үнэлгээгээр матриц байгуулах аргыг өргөн ашигладаг. Энэ аргын нэг хувилбар нь Леопольдын матриц юм. Бид энд Леопольдын матрицыг химийн бодисыг тээвэрлэлт, хадгалалтын процесс явагдах үеийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажилд зориулан бага зэрэг хувиргасан байдлаар ашигласан болно. Үүний тулд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд (агаар, хөрс, ус, ургамал, амьтан г.м)-ийн чухам ямар үе шатанд нь илүү их нөлөөлөлд өртөж байгаа тухай экспертүүдийн үнэлгээг үндэс болгон тогтоолоо.

Леопольдын матрицын аргаар дүгнэж үзэхэд Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагааны үе шатуудаас эдийн засаг, ажиллагсдын эрүүл мэндэд хамгийн их нөлөөлөл үзүүлэхээр байна. Газар доорх ус, газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөгт үзүүлэх нөлөө их биш ч бодис асгарсан тохиолдолд газрын гадарга, хөрсөн бүрхэвч болон газар доорх усанд маш хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Эдгээр нөлөөллийг бууруулах, үүсэхгүй байх боломжтой бөгөөд төслийн үйл ажиллагааны үед үүсэх гол нөлөөллийг химийн бодисын асгаралт, алдагдалаас үүсэх аюул байна гэж үзлээ. Ингээд энэ нөлөөллийн талаар эрсдлийн үнэлгээний хэсэгт аргачлалын дагуу тусгайлан тооцож үнэлсэн болно.

Хүснэгт 4. Төслийн голлох сөрөг нөлөөлөл

| Эх үүсвэр | Хөрс | Агаар | Эдэлбэр газар |
|--|---|---|---------------|
| Химийн түүхий эдийн сав, боодлын хаягдал | Химийн бодисын хаягдал сав, боодлын хаягдал | | |
| Агуулах орчны тоосжилт | | Бодис тээвэрлэх явцад агаарт тоосжилт үүснэ. | |
| Ахуйн хог хаягдал үүсэх | Хог хаягдлын судалгаанаас үзвэл өдөрт 1.5 кг, 1 жилийн хугацаанд 370.5кг ахуйн хатуу хог хаягдал гарах болно. | | |
| Төслөөс үзүүлэх дуу чимээ | | Агуулахын дотоод агаар орчинд дуу чимээний тархалт үүснэ. | |

3.2.1. Газрын гадрага, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй нөлөөлөл

Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагаа нь хөрсний элэгдэл, бохирдолд шууд нөлөөлөх ба төслөөс бий болох аюултай болон хатуу хаягдлыг задгай хаягдлын цэг байгуулснаас болон хогийн цэгийг ариутгаагүй удах, хогийг зохих график хуваарийн дагуу ачихгүй байх зэрэг шалтгаанаас хөрс бохирдох, мөн химийн гаралтай бодисыг тээвэрлэлтийн үед алдаж асгах тохиолдолд газрын гадарга бохирдох зэргээр сөрөг нөлөөлөл гарах эрсдэлтэй байна.

Гол сөрөг нөлөөлөл

Хүснэгт 5. Төслөөс газрын гадаргад нөлөөлөх байдал үнэлгээ

| НӨЛӨӨЛӨЛ | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | |
|---|--------------------------------|------|----|-------------|
| | Бага | Дунд | Их | Онц Аюултай |
| Ахуйн хог хаягдлыг тогтоосон цэгээс өөр газарт хаяж, хөрс бохирдуулах | х | | | |
| Химийн бодисыг зөөж тээвэрлэх үед санамсаргүй асгарч хаягдах | | х | | |
| Тээвэрлэлтээс тоосжилт үүсэх | х | | | |
| Нийт нөлөөллийн агуулахаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөх нөлөөллийг “БАГА” гэж үзлээ. | | | | |

Тус Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутагт хэрэгжих Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга болон хэвлийд нөлөөлөх нөлөөлөл бага зэрэг сөрөг нөлөөлөлтэй байна.

3.2.2. Уур амьсгалд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн уур амьсгалд шууд нөлөөлөхгүй. Харин байгалийн аюултай үзэгдлүүд, хүчтэй салхи, шороон шуурга, бороо, үер зэрэг уур амьсгалын хүчин зүйлсээс Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй.

3.2.3. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн онцлогоос шалтгаалан химийн бодис орчинд алдагдах, агаартай харилцан урвалд орж болзошгүй бөгөөд уг эрсдэлийг энэхүү тайлангийн хүний эрүүл мэнд болон экологийн өртөлтийн үнэлгээнд дэлгэрэнгүй авч үзсэн.

Хүснэгт 6. Төслөөс агаарын чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

| НӨЛӨӨЛӨЛ | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | |
|---|--------------------------------|------|----|-------------|
| | Бага | Дунд | Их | Онц Аюултай |
| Химийн бодисыг хадгалах үед агуулахад химийн бодис уурших дотоод агаарын бохирдол үүсэх | х | | | |
| Ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх | | х | | |
| Агуулахын дотоод орчиноос гадагш агаарын бохирдол алдагдах | х | | | |
| Химийн бодисыг зөөж тээвэрлэх болон агуулахаас ачих, буулгах тээврийн хэрэгслээс ялгарах утаа орчинд нөлөөлөх | | | х | |
| Нийт нөлөөллийн агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийг “БАГА” гэж үзлээ. | | | | |

3.2.4. Гадаргын болон газрын доорхи усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд гадаргын ус байхгүй байна. Харин төсөл хэрэгжүүлэгч химийн бодисоо болгоомжгүй байдлаасаа болж асгавал хөрсөнд нэвчсэн бодис гүний усанд нөлөөлнө.

Хүснэгт 7. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

| № | Сөрөг нөлөөлөл | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | |
|---|--|--------------------------------|------|----|--------|
| | | Бага | Дунд | Их | Хүчтэй |
| 1 | Төслийн үйл ажиллагаагаар гадаргын усан сүлжээ өөрчлөгдөх | х | | | |
| 2 | Агуулахын үйл ажиллагааны улмаас газрын доорх усны нөөцөд нөлөө үзүүлэх | | х | | |
| 3 | Газар доорхи усны баланс алдагдах, химийн найрлага нь өөрчлөгдөж бохирдох | | х | | |
| 4 | Төслийн үйл ажиллагаанаас гарах ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал нь газрын доорх усны чанарт сөрөг нөлөө үзүүлэх | | х | | |

Нийт нөлөөллийн усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл ДУНД зэргийн нөлөөлөл үзүүлэхийг харуулж байна.

3.2.5. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих талбайд ахуйн болон агуулахын хог хаягдлыг зориулалтын дагуу хогын цэгт хаяхгүй ил задгай хаяснаас болж химийн бодис хөрсөнд нэвчих амьтад хортох элдэв өвчин тусах зэрэг сөрөг нөлөөллүүд бий болно.

Хүснэгт 8. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

| № | Нөлөөлөл | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | |
|---|--|--------------------------------|------|----|--------|
| | | Бага | Дунд | Их | Хүчтэй |
| 1 | Агуулахын үйл ажиллагааны нөлөөнд үржил шимт хөрс бүхий талбай өртөх | х | - | - | - |
| 2 | Агуулахын үйл ажиллагааны үед ахуйн гаралтай хаягдал, химийн бүтээгдэхүүний хаягдлаар хөрсөн бүрхэвч бохирдох | - | х | - | - |
| 3 | Хөрсний шимт бодисын нөөц хомсдох, хөрсний гадаргын ургамал бүрхэц сийрэгжсэнээр хөрс эвдрэх үйл явц түргэсгэх | х | - | - | - |
| 4 | Хөрсний хими, физик, геохими, биохимийн хөдлөл зүйн горим өөрчлөгдөх | х | - | - | - |
| 5 | Хөрс хуурайшиж, бүтэц нь алдагдаж, элэгдэх, механик үйлчлэлээр талхлагдаж сийрэгжих, нимгэрэх | х | - | - | - |
| 6 | Хог ургамалд баригдах, доройтох, ахуйн хогоор бохирдох, | - | х | - | - |

Нийт нөлөөллийн хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл БАГА байгааг харуулж байна.

3.2.6. Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Ургамлан бүрхэвч нь мал болон зэрлэг амьтны тэжээл төдийгүй хөрсний дээд давхаргын дулаан ба чийгийг зохицуулагч, хөрс үүсгэгч, бэхжүүлэгч экосистемийн хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Ургамал нөмрөгийн талхагдал дунд зэрэг буй энэ орчимд хүн болоод машин техникийн нөлөөтэй учраас талхагдалд орсон.

Ургамлан нөмрөгийн шууд бус нөлөөлөлд өртөх хэсгийг хүн машин байнга зорчихгүй боловч талхлах, агаараар дамжуулан бохирдол зөөгдөх талбайн хэмжээгээр бүс үүсгэн тогтоосон ба энэ хэсэгт хөрс сүвэрхэгжиж, ус хадгалах чанар болон хуваарилалтад илүү их өөрчлөлт гарч ургамал ургах нөхцөл нь доройтсоноор экосистемийн хуурайших үйл явц эрчимжиж, унаган ургамал үгүй болж бусад хүмүүнсэг ургамлаар солигдох болон ургамлын тусгагийн бүрхцийн бууралт ажиглагдана.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл нь бодис тээвэрлэлт үед асгарах алдагдах эрсдэл бий болж болох бөгөөд үүнээс үүдэн ургамал талхлагдах, устгах эрсдэл бий болох магадлалтай.

Хүснэгт 9. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

| № | Сөрөг нөлөөлөл | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | |
|--|--|--------------------------------|------|----|--------|
| | | Бага | Дунд | Их | Хүчтэй |
| 1 | Агуулахын үйл ажиллагааны нөлөөнд үржил шимт хөрс бүхий талбай өргөж ургамлан нөмрөгийн байгалийн унаган төрх алдагдах | х | | | |
| 2 | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед гарах тоосоор тодорхой талбайн ургамал дарагдах | | х | | |
| 3 | Ашиглалтад өртөх талбайн ургамлан нөмрөг бүхэлдээ устаж үгүй болно | х | | | |
| 4 | Тээврийн хэрэгслийн нөлөөгөөр ургамлан нөмрөг тоосонд дарагдах | х | | | |
| Нийт нөлөөллийн ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл БАГА байгааг харуулж байна. | | | | | |

3.2.7. Амьтны аймагт нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөө

Тус Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт “Сика Монголиа” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй болно.

3.2.8. Нийгмийн эрүүл мэндэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөө

Зориулалтын хувцас, хэрэгслийг стандарт шаардлагын дагуу хэрэглэхэд төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд шууд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл байхгүй болно.

3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

“Сика монголиа” ХХК-ийн төслийн бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох хадгалах ашиглах агуулахын үйл ажиллагааны явцад гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, химийн бодис, материалыг байгаль орчин, экологид хор хөнөөлгүйгээр хадгалах болон тэдгээрийг хамгийн бага сөрөг нөлөөлөлтэйгээр хадгалах, зөөвөрлөх, устгах, зайлуулах, нөхөн сэргээх замаар тухайн орон нутгийн байгалийн өнгө төрх, хэлбэр, хор аюулгүй нөхцөлд орон нутгийн хүн ам, амьтан ургамал, үржин төлжих нөхцөлийг бүрдүүлэхэд төслийн үйл ажиллагааны гол зорилго оршино. Иймд төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

3.3.1. Цаг уур, уур амьсгалаас үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Химийн бодисуудын хадгалалт, тээвэрлэлтийн үед цаг агаарын болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд хадгалж буй агуулах нь доор дурдсан шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

- Химийн бодисын агуулахын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүрэн бүтэн байдал, химийн бодисын савны болон асгарсан бодис тарахаас сэргийлсэн тосгуур, суурины зузаан, идэгдэлт, химийн бодис тавьсан тавиур болон холбоосны механик бүрэн бүтэн байдал, тавиур дээр хадгалж буй бодисын дээд хэмжээг байнгын хяналт тавихаас гадна шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг тогтмол хугацааны давтамжтайгаар хийж, тэмдэглэл хөтөлж байх.
- Химийн бодисын агуулахын ажлын байр нь галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалгатай байхаар засаж

тохижуулах.

- Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.
- Бүх химийн бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгалах, барилгад аянга зайлуулагч тавих зэрэг болно.

3.3.2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн хортой болон аюултай бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа уурших, задрах гэх мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савалгааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг эхэлж ашиглах зарчмыг баримтлах.
- Химийн бодисын агуулахын хадгалах нөхцлийг стандартын шаардлагын түвшинд тохижуулах, хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсан зааврын дагуу хадгалах, ялангуяа химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсаны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.
- Агаарын чанарын хяналтын хэмжилт хийх ажилтанг томилох, хавсран гүйцэтгэх тохиолдолд ажил үүргийнх нь хуваарьт оруулах.
- Агуулахын гадаад болон дотоод орчноос ОХШХ-т тусгасан үзүүлэлтээс сорьц авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах.
- Тээвэрлэлт хийдэг машины хурдны хязгаарлалтыг зааж, асаалттай орхихгүй байх
- Шороо тоос дэгдэхээс урьдчилан сэргийлж, агуулахын гадна талбайн хатуу хучилтыг хагарал гарсан тохиолдолд нөхөх, дулааны улиралд усалгаа хийх.

3.3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Цементэлсэн талбайд хагарал гарсан тохиолдолд тухай бүр нь засварлах.
- Аюултай хог хаягдлыг хадгалах байрыг агуулахаас тусад нь гаргаж шалыг хатуу хучилттай болгох.
- Химийн бодис, аюултай хог хаягдлын хадгалалтад тавих хяналтыг тогтмол байхаар ажиллагсдын ажил үүргийн хуваарьт тусгаж, ажлын график гарган мөрдүүлэх.
- Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх.
- Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх.
- Химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх зэрэг болно.
- Хөрсөн орчныг хамгаалах, нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь ургамал, амьтан, усны нөөцийг хамгаалах үйл ажиллагаатай нягт уялдаатай юм. Цаашид төв замаас төслийн талбайн хашааны гаднах зам хүртэл талбайд мод бут тарьснаар тухайн орчинд бичил био орчин үүсэж, төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг саармагжуулах боломжтой.

3.3.4. Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу явуулах, усан орчинд нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэх
- Химийн бодисын агуулахад химийн бодис, бүтээгдэхүүнийг татан авчрах, хүлээн авах үйл ажиллагааг явуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах ажиллах зэрэг болно.

3.3.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн бодисын аюулгүй ажиллагаа, түүнийг зөрчсөнтэй холбоотой осол аваар нь голдуу химийн бодис зөөвөрлөх машин, техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны горим алдагдсанаас үүдэлтэй байдаг. Химийн хортой болон аюултай бодисыг тээвэрлэх болон устгах үеийн аюулгүй ажиллагаа зөрчигдсөнөөс болон ургамлан нөмрөг, ургамалжилтад үзүүлэх сөрөг нөлөөлөл илүү байна. Иймээс химийн бодис тээвэрлэх, хадгалах журамд заагдсаны дагуу алдаж асгахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй.
- Төслийн талбайн ашиглагдаагүй хэсэгт мод бут, зүлэг ногоо тарих.

3.3.6. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг үйл ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын уураар амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах.
- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих.
- Химийн бодисын агуулахад ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх.
- Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн байгууллагын даргаар батлуулан ажлын байр болон агуулахад химийн бодистой харьцаж ажилладаг ажилтан өдөр тутмын ажиллагаанд ашиглаж байх боломжтой харагдахуйц газарт байрлуулах бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгаанд химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл /хүний эрүүл мэнд, байгаль орчин/, химийн бодистой харьцах, хадгалах зааварчилгаа, асгарч алдагдсан болон галын аюулын үед авах арга хэмжээ, анхны тусламж, хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглэх заавар, хаягдлыг устгах зааварчилгааг зэргийг багтаасан байна.
- Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх, хадгалахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулахаас гадна болзошгүй аюул, осол гарсан үед хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд үүсэх хохирлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дарааллыг тогтоосон “Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” боловсруулж, тухайн орон нутгийн Онцгой байдлын газраар батлуулсан хэрэгжүүлэх.
- Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтад заавал хамруулсан байх.

- Химийн бодисын агуулахын болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу бүрэн ажиллагаатай гал унтраах багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, химийн бодис асгарч алдагдсан үед ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгсэл (арьс, нүд, амьсгал хамгаалах), амьсгал хамгаалах баг, нүд угаах болон ослын шүршүүр зэргийг ажлын байранд байршуулж, тэдгээрийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг тогтмол шалгаж байх, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлэх.
- Химийн бодисын агуулахад утаа мэдрэгч, галын дохиоллын систем, даралт мэдрэгч болон тэсрэлт үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хий зайлуулагч автомат төхөөрөмж суурилуулах зэрэг болно.

3.3.7. Химийн бодис материал алдагдсан үед авах арга хэмжээ, зөвлөмж

“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 2.1.2-д химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг үйлдвэрлэгчээс гаргасан ХАЛМ-д үндэслэн боловсруулж өөрийн байгууллагын даргаар батлуулсан байх ёстой хэмээн заасан байдаг. Мөн журмын 2.1.5-д болзошгүй аюул, ослын үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөгөө боловсруулж, тухайн орон нутгийн онцгой байдлын газраар батлуулсан байна хэмээн заасан байдаг.

Тус химийн бодисын агуулахын үйл ажиллагааг эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж батлуулах шаардлагатай байна. Аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж боловсруулахад дараах зөвлөмжүүдийг тусгах хэрэгтэй. Үүнд:

- Их хэмжээгээр ус, хөрсөнд алдагдсан тохиолдолд “Орон нутгийн онцгой байдлын алба”-нд мэдээлэл яаралтай хүргэж, тархах хүрээг хумих боломжит арга хэмжээг авч, рН-ийг өсгөх, саармагжуулах зорилгоор шингээж авахаар модны үртэс дээр нь нэмнэ.
- Бодис материалууд их хэмжээгээр ус, хөрсөнд алдагдсан тохиолдолд “орон нутгийн онцгой байдлын алба”-нд мэдээлэл яаралтай хүргэж, дээрхи аргуудаар осол аюулын зэрэглэлийг бууруулах шаардлагатай бөгөөд аюул ослын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар холбогдох байгууллагуудад тайлагнах шаардлагатай.

3.3.8. Химийн бодисын хаягдлыг хадгалах, тогтворжуулах зөвлөмж

Төсөлд химийн бодисыг импортлохдоо түүхий эдийн савыг дахин ашиглах тул энэ төрлийн хаягдлууд үйл ажиллагааны явцад гарахгүй боловч химийн бодисын сав баглаа боодол задрах, ашиглалтын шаардлага хангахгүй болсон тохиолдолд химийн бодисын болон химийн бодис агуулсан сав баглаа боодлын хаягдал гарах магадлалтай. Иймд химийн бодисын хаягдлыг түр хадгалах цэг байгуулан 1м³ багтаамжтай хоосон саванд битүүмжлэн түр хадгалж “Химийн хортой аюултай хаягдлыг устгах, боловсруулах, булшлах байгууламж”-д нийлүүлэх шаардлагатай.

3.3.9. Удирдлага, зохион байгуулалтын талаар

“Химийн хортой болон аюултай бодисын тухай” Монгол улсын хууль Химийн хортой болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх худалдах журам, Химийн хортой болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх ашиглах устгах журам, зэрэг хууль, журам тогтоол дүрэм зэргийг нарийн баримталж ажиллах.

Тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хортой болон аюултай бодис худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр, төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж нэг хувийг худалдан авагчид, үлдсэн хувийг өөртөө хадгална.

Химийн хорт болон аюултай бодисыг худалдахдаа худалдан авагчид тухайн бодисын хор, аюулгүй ажиллагааны лавлах мэдээллийг заавал дагалдуулан өгнө.

Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодис нь зориулалтын сав баглаа боодолтой байх, тухайн бодисын сав баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг аюулын шинж чанарыг тод, томоор бичсэн шошготой байна.

Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын тайланг БОАЖЯ-нд жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор гаргаж өгнө.

3.3.9.1. Орчныг бохирдлоос хамгаалах талаар

- Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн бодис нэг бүрээр боловсруулсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг байгаль орчны болон гамшгаас урьдчилан сэргийлэх хяналтын улсын байцаагчаар хянуулж, өөрийн байгууллагын даргаар баталгаажуулсан байна.
- Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсээр батлуулсан байна.
- Харилцагч байгууллагуудаас химийн бодисын захиалга авахдаа тэдгээрийн нэр төрөл, тоо хэмжээг нарийн тодорхойлж аль болох борлуулалтаас үлдэгдэл гарч агуулахад хадгалагдахгүй байхаар зохион байгуулах.
- Импортоор оруулан авчрах химийн бодис, материал нэг бүрийн хими, физикийн шинж чанар, хор аюулын зэрэг, тээвэрлэлт, хадгалалтын онцлог нөхцлийн талаар нарийн тээвэрлэх, захиалагч байгууллагад нийлүүлэх, агуулахад хадгалах үйл ажиллагааны үед удирдлага болгох.
- Химийн бодис, материалыг тээвэрлэхдээ зохих байгууллагаас зөвшөөрөл авч шаардлага хангасан сав, баглаа боодолтой, хагарч асгарч гэмтэхээргүй зөөлөвч жийрэгтэйгээр, нийтэд сэрэмжлүүлсэн таних тэмдэг, анхааруулсан тод бичигтэйгээр зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- Химийн онцгой хортой бодисын санамсаргүй алдагдал гарсан тохиолдолд хорыг саармагжуулах, ариутгал цэвэрлэгээ хийх, үлдэгдэл хаягдлыг устгах талаар яаралтай авч хэрэгжүүлэх зааварчлагааг бодис нэг бүрээр гаргаж агуулахын ажиллагсадад эзэмшүүлэх.

3.3.9.2. Ажиллагсдын эрүүл ахуйг хамгаалах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах талаар

- Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагсдыг бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээний талаар сургалтанд хамруулж, гарын үсэг зуруулсны дараа ажиллуулах ба сургалтанд хамрагдаагүй тохиолдолд химийн бодистой харьцаж ажиллахыг хориглох.
- Агуулахын байрны агаар дахь химийн хор аюултай бодисын агуулга, температур, чийгшил, тоосжилтын түвшин зэрэгт хяналт тавих багаж хэрэгсэлтэй болох арга хэмжээг ойрын үед авах.
- Ажиллагсадад химийн бодис, материалыг ачих, буулгах, зөөх үедээ ажлын тусгай хувцас, техник хэрэгслийг ашиглан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг нарийн баримтлан ажилладаг дадал зуршлыг хэвшүүлэх.
- Онцгой нөхцлийн үед ашиглах хөдөлмөр хамгааллын тусгай хувцас, багаж, техник хэрэгслийн зохих нөөцийг бүрдүүлэх.
- Ажлын байранд мэргэжлийн хяналт, орчны мониторингын болон эрүүл ахуйн байгууллагаар тухай бүр хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулж байх. Өөрөөр хэлбэл ажлын байрын эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын аттестатчилалд байнга хамрагдаж байх .

3.3.9.3. Сургалт судалгааны талаар

- Тус компаний стратегийн болон ойрын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн технологийн менежмент (сургалт, сургалчилгаа, орчны хяналт)-ийг хөгжүүлэх, удирдлагын байгаль орчин, эрүүл ахуйн талаарх мэдээллийг сайжруулах.
- Агуулахын ажиллагсад зориулсан байгаль орчин, үйлдвэрлэлийн экологийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.
- Химийн бодис, материалын агуулахын үйл ажиллагааг хэвийн явуулах, аливаа гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэх аргын үндэс болсон хөдөлмөр хамгааллын зааварчилгааг тогтмол өгч, мөрдөлтөд нь байнга хяналт тавьж байх.
- Хаягдал, бохирдолд тавих байгаль орчны салбарын олон улсын нормативыг технологийн үйл ажиллагааны дамжлага тус бүр дээр мөрдөж ажиллах, орчны хяналт шинжилгээг жил бүр тогтоосон хугацаанд хийлгэж хэвших.

4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

4.1. Эрх зүйн үндэслэл ба түүний гол шаардлага

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ), Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс (ОХШХ) бүрдэх бөгөөд БОХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, ОХШХ-т т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан тус тус боловсруулав.

Нөгөө талаас төслийг хэрэгжүүлэгч “Сика Монголиа” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

Энэхүү БОМТ-г боловсруулахдаа Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалын баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болголоо.

4.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Химийн бодисыг хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанаас үзүүлж болох болзошгүй болон голлох нөлөөлөлд химийн бодисын хадгалалт, аюулгүйн ажиллагаа болон ажлын байрны эрүүл ахуйн бичил орчны нөлөөлөх байдал нь голлох нөлөөлөлд хамаарахаар байна.

Иймээс төсөл хэрэгжүүлэгч ажиллагсдын ажиллах орчин, хөдөлмөр хамгаалал, химийн бодисын эрсдлийн менежментийн асуудал дээр гол анхаарлаа хандуулж, 2007 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 151/126/52 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, MNS 4585-2016. Агаар орчны чанарын

үзүүлэлт. Ерөнхий шаардлага, MNS 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах”, БНБД 21-04-05. Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл, MNS 5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага зэрэг стандартуудыг нарийн баримтлан ажиллаж, тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл (MSDS)-д заагдсаны дагуу химийн бодис бүртэй харьцаж ажиллах шаардлагатай.

БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11 сарын 1-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийн хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тусгасан болно.

Мөн “Сика” групп нь Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг биелүүлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулах зорилгоор бүх салбар компаниудаа “Тогтвортой Байдлыг Тайлагнах Удирдамж”-ийн дагуу тайланг бэлтгэхийг шаарддаг.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, арга хэмжээний төлөвлөгөө.

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд | Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Нэгжийн өртөг /Мян.төг/ | Нийт зардал мян.төгрөг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах хууль журам стандарт |
|--|---|------------------------------|-------------------------|------------------------|--------------------------------|--|
| 1. Агаар орчны асуудлаар | | | | | | |
| Агуулахын хөрсний элэгдлээс үүдэлтэй тоосжилт болон химийн бодисын ууршилтын үр дүнд ялгарах хий зэрэг нь агаарын тоосжилт ба бохирдолтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх эх үүсвэр болно. | Агуулахын тоосжилт, чимээ шуугиан, температурын хяналт, чийгшил, гэрэлтүүлэгт хэмжих, мониторинг хийх, сайжруулах | Агуулах | 200.0 | 200.0 | 2024-2028 | MNS 0012-013:1991. Ажлын байрын агаар. Ажлын байрны агаарын бүс MNS17.2.3.16-88. ”Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам |
| | Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд шинжилгээ хийлгэх (жилд 1 удаа) | | ОХШХ-г тусгасан | | 2024-2028 | УСТ3384-82”. Агаар мандлын сорьц авахад тавих ерөнхий шаардлага |
| | Орж гарах машины явах замыг услах | Төслийн орчинд | ҮАЗ | ҮАЗ | 2024-2028 | |
| Химийн бодисын хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалахад өндөр температурт хэт халснаас тэсэрч, дэлбэрэх, уурших, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах | Нарны шууд тусгалд өртөх агуулахын цонхонд нарны гэрэл сааруулах хуулга наах | Агуулах | 300.0 | 300.0 | 2024 | Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам |
| Нийт | | | 500.0 | 500.0 | | |
| 2. Дуу чимээ | | | | | | |
| Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны | Сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглэх самбар, тэмдэг тэмдэглэгээ, | Химийн бодис ачиж буулгахдаа | 200.0 | 200.0 | 2024-2028 | MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ MNS 5002:2000 |

| | | | | | | |
|--|--|--|---|-----|-----------|--|
| шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ. | зааварыг ажлын байранд байрлуулах, сонсгол хамгаалах хэрэгслээр хангах | | | | | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага |
| | Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийх, | Агуулахын газар дотор болон гаднах талбайд | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | - | 2024-2028 | |
| Нийт | | 200.0 | | | | |
| 3. Хөрсөн бүрхэвчийн асуудлаар | | | | | | |
| Ахуйн хатуу хог хаягдлыг тодорхой зохицуулалтгүй хаях нь хөрсний бохирдлын гол эх үүсвэр болох | Ахуйн хатуу хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, тогтмол хугацаанд зайлуулах | Гэрээний дагуу | ҮАЗ | ҮАЗ | Тухай бүр | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| | Агуулахын орчны хөрсний шинжилгээг хийлгэх | Агуулахын гадна орчинд | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу | | 2024 | |

| | | | | | | |
|---|---|---------------------------|--------------|-------|-----------|--|
| Химийн бодисын санамсаргүй алдагдал, ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт төвлөрүүлж графикт хугацаанд ачиж зайлуулахгүй байх зэрэг нь хөрснийг бохирдуулна. | -Бодисыг их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажиллах -Асгарсан тохиолдолд MSDS-д заасны дагуу яаралтай арга хэмжээ авах -Хүнсний сод, элс, шороог бэлэн байлгах | Агуулахын ойр орчимд | ҮАЗ | ҮАЗ | 2024-2028 | |
| Нийт | | | - | - | | |
| 4.Амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах | | | | | | |
| Зэрлэг ан амьтадыг хамгаалах | Байгалийн зэрлэг ан амьтадад өвс тэжээл, хужир мараа тавьж өгөх | Төслийн үйл ажиллагаагаар | 500.0 | 500.0 | 2024-2028 | -- |
| Нийт | | | 500.0 | | | |
| 5. Усан орчин үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах | | | | | | |
| Төслийн явцад усыг их хэмжээгээр, замбараагүй хэрэглэсэн тохиолдолд усны нөөцөд шууд нөлөөлөх магадлалтай | Ахуйн болон үйл ажилгааны зориулалттай ус ашиглалтын дүгнэлт гаргуулж ажиллах, усны эх үүсвэрийг тодорхой болгох | Төслийн хүрээнд | ҮАЗ | ҮАЗ | 2024-2028 | -Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Усны тухай хууль |
| Нийт | | | - | - | | |
| 6. Удирдлага зохион байгуулалтын талаар | | | | | | |
| Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх | | | - | - | | Компаний дотоод журмаар |
| Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, | | Агуулахын ажилчидад | ҮАЗ | ҮАЗ | 2024-2028 | |
| Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах | | | ҮАЗ | ҮАЗ | 2024-2026 | |
| Ажиллагсдад хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх | | | ҮАЗ | ҮАЗ | | |
| Ажлын байранд аюулгүйн шүршүүр болон нүд угаах зориулалтын угаалтууртай болгох | | | ҮАЗ | ҮАЗ | 2024 он | |

| | | | | | |
|--|--|-----------------------|-----|--------------|---|
| Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар 2 жил тутам хийлгэх | | ҮАЗ | ҮАЗ | 2 жил тутамд | Монгол Улсын Газрын тухай хуулийн 58-р зүйл |
| Газрын чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар 5 жил тутамд хийлгэх | | ҮАЗ | | 5 жил тутамд | |
| Нийт дүн | | 1,200.0 төгрөг | | | |

6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ургамлан нөмрөг хамгаалах/

| Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээх арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /мян.төгрөг/ | Нийт зардал /мян. төгрөг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|--|----------------------------|----------------------------|---------------------------|--------------------------------|--|
| Төслийн орчинд, ногоон байгууламж бий болгох | Ашиглагдаагүй хоосон талбайг ургамалжуулах | Төслийн талбайд | 330.0 | 330.0 | 2024-2028 оны хавар | Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт. MNS5914:2008; Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MNS5916:2008; Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS5918:2008; MNS 6258-1:2011. Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага MNS 6258-2:2011. Мод, сөөгний суулгац арчлах MNS 6774:2019. Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах. Техникийн шаардлага |
| Ногоон байгууламжинд арчилгаа тордолгоо хийх | Ногоон байгууламжын усалгаа, тайралт, хэлбэржүүлэлт хийх | Төсөл хэрэгжих орчинд | 90.0 | 90.0 | 2024-2028 он | |
| | | | | Нийт | 420.0 төгрөг | |

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай орчимд улсын болоод орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг үгүй бөгөөд өмнө нь Монголын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн хийсэн судалгаанаас үзвэл түүх дурсгалын болон соёлын өв болох зүйл байхгүй болно. Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай. “Сика Монголиа” ХХК-ийн төслийн байршил, онцлогоос хамаараад түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний ажил хийгдэхгүй болно.

8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Нэгжийн өртөг | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|--|---------------|-----------------------|--------------------------------|---|
| Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс болж гал гарч химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүснэ. | Байгаль хамгаалал, болзошгүй түймрээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааныг самбар хийж байрлуулан, тухай бүрд нь шинэчилж байх | 150.0 | 150.0 | Төсөл хэрэгжих хугацаанд | - |
| | Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах (амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат, галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт) | ҮАЗ | ҮАЗ | 2024 онд | MNS8 5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага |
| | Бодис урвалжуудын хор аюулын зэргийг харуулсан тэмдэг, тэмдэглэгээг монгол тайлбараар дэлгэрэнгүй хийх | ҮАЗ | ҮАЗ | 2024 онд | MNS5029:2011. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг. |
| | Химийн бодисын хадгалалт, аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулж байх | 2,500.0 | 2,500.0 | 2024 | Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014 |
| | Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах | ҮАЗ | ҮАЗ | 2024 | Гамшгаас хамгаалах тухай хууль |

| | | | | | |
|--|--|-----------------------|-----|-----------|--|
| Химийн бодис их хэмжээгээр асгарвал аюултай нөхцөл байдал үүснэ. | Ослын үед ашиглах гар болон автомат ажиллагаатай дуут дохиололтой болох | ҮАЗ | ҮАЗ | 2024 онд | MNS 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах” |
| | Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл*, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгсэлийг бэлэн байлгах | ҮАЗ | ҮАЗ | 2024-2028 | |
| | Онцгой байдлын үед, осол гэмтлийн үеийн бэлэн байдал, анхны тусламж үзүүлэх, ажилчдын амрах, хувийн ариун цэвэр хангах зориулалт бүхий анхны тусламжийн өрөө, амралтын өрөөг бэлтгэж, шаардлагатай хэрэгслээр хангах, тохижуулах | ҮАЗ | ҮАЗ | 2024 | |
| | Болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх зориулалтын шингээгч, хүнсний сод, хуурай элс, шороо, тогтворжуулагч, үртэс гэх мэт материалуудыг ажлын талбарт бэлэн байлгах | - | ҮАЗ | 2024 онд | Тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл |
| Химийн бодисын хадгалалтын стандартыг зөрчиж буруу байрлуулснаас эрсдэл үүснэ. | Агуулахад хадгалах бодисуудыг цуг хадгалж болох, болохгүйгээр ангилах | - | ҮАЗ | 2024 онд | |
| | Тавиур дээр тавьж хадгалах | - | ҮАЗ | 2024 онд | |
| Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал | | 2,650.0 төгрөг | | | |

8.1 Химийн бодисын ослын үед авах арга хэмжээ

Химийн бодисын нөлөөнд өртсөн тохиолдолд авах арга хэмжээний талаарх мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 13. Химийн бодисын ослын үед авах арга хэмжээ, зөвлөмж

| № | Бодисын төрөл | Анхаарах зүйлс | Авах арга хэмжээ | Хаягдал зайлуулалтын үед авах арга хэмжээ |
|---|--------------------------------------|--------------------------|--|---|
| 1 | Усны орцыг багасгах төрлийн бодисууд | Арьс, ба нүдийг цочрооно | Нүдэнд орсон үед: Зовхийг нээлттэй байлгаж доод тал нь 15 минутын турш усаар угаана. Нүдний эмчээс зөвлөгөө авна. Арьсанд хүрсэн үед: Ус, савангаар сайтар угаа. Хэрэв үрэвсэл арилахгүй байвал эмнэлгийн тусламж ав. | Энэхүү бодисыг шатамхай уусгагчид уусгах буюу холих ба тусгайлан тоноглогдсон химийн хаягдал шатаах зуух буюу скрубберт шатаана. Хоосон бортогыг сайтар шавхаж, сайтар таглаж |

| № | Бодисын төрөл | Анхаарах зүйлс | Авах арга хэмжээ | Хаягдал зайлуулалтын үед авах арга хэмжээ |
|---|--|---|---|---|
| | | | Амьсгалсан үед: Үйлдвэрлэлийн ердийн хэрэглээний үед аюулгүй, хэрэв ууранд нь үлэмж хэмжээгээр өртсөн бол цэвэр агаарт гарах ба хэрэв ханиалгах болон бусад шинж тэмдэг илэрвэл эмнэлгийн тусламж ав. Залгисан үед: Амаа тэр даруйд нь усаар зайлах ба дараа нь их хэмжээний ус уулгах. Эмчийг яаралтай дуудах. Ухаан алдсан хүнд амаар нь ямар нэгэн юм хэзээ ч бүү өг. | битүүмжлэн бортого дахин сэргээх газар руу нэн даруй илгээнэ. |
| 2 | Хөдөлгөөн багасгах болон гадаргууг бэхжүүлэгч үйлчлэл бүхий бодисууд | Залгисан бол аюултай. Арьсыг үрэвсүүлнэ. Нүдэнд ноцтой гэмтэл учруулах эрсдэлтэй. Бохир усны хоолой болон усны дамжуулах суваг руу хаяж болохгүй. | Залгисан үед: Залгисан тохиолдолд боломжтой газарт нэн даруй эмнэлгийн тусламж авна. Эмнэлгийн тусламж тэр даруй авах боломжгүй бол: Ухаан алдаагүй бол ус уулгах. Зөвхөн ухаан алдаагүй байгаа тохиолдолд л хоолой руу хуруугаа хийн бөөлжих явцыг дэмжиж өгнө. Өвчтөнийг урагш бөхийлгөх, эсвэл зүүн талаар нь хэвтүүлж агаараар хангана (боломжтой бол толгойг нь доош харуулах). Сануулга: Механик арга хэрэглэн бөөлжих явцыг дэмжихдээ хамгаалалтын бээлий өмсөнө. Нүдэнд орсон үед: Тэр даруйд нь нүдний зовхийг хөндийрүүлэн нээж бариад усаар урсган сайтар угаана. 15 минутаас багагүй хугацааны турш нүдийг усаар тасралтгүй зайлна. Нүдийг зайлахдаа хлорт устөрөгчийг ашиглана. Цаг алдалгүй эмнэлэг, эмчид хүргэнэ. Нүд гэмтсэн тохиолдолд нүдний контакт линзийг зөвхөн мэргэжлийн ажилтнаар авхуулна. Арьсанд хүрсэн үед: Бүх бохирдсон хувцас, гутлыг нэн даруй тайлна. Арьс, үсийг усаар зайлна (боломжтой бол савангаар). Цочрол өгсөн тохиолдолд эмнэлгийн тусламж авна. Амьсгалсан үед: Уур буюу шаталтын бүтээгдэхүүнийг нь залгисан бол бохирдсон газраас холдуулна. Шаардлагатай тохиолдолд эмч дууд. | Бүхий л хаягдлыг улсын хэмжээний хууль тогтоомжид нийцүүлэн устгана. Бодисын савыг дахин ашиглахаас сэргийлэн цоолж, зөвшөөрөгдсөн хогийн цэгт булна. Төхөөрөмжийг цэвэрлэсэн усыг усны хоолой руу оруулж болохгүй. Устгал хийхийн өмнө угаалгад ашигласан бүх усыг боловсруулалт хийх зорилгоор цуглуулан авна. Устгалын талаар хаягдлын удирдлагын газартай зөвлөх. Үлдэгдлийг зөвшөөрөгдсөн газарт булах буюу шатаах. Савыг боломжтой бол дахин боловсруулалтад оруулах буюу зөв зөвшөөрөгдсөн цэгт устгах |
| 3 | Усны нэмэлт болон бэхжилтийг түргэсгэгч | Галд өртвөл шатна | Нүдэнд орсон үед: Дор хаяж 15 минутын турш усаар зайлах. Эмнэлгийн тусламж яаралтай авах. Арьсанд хүрсэн үед: Бодис дуссан хувцсыг тайлж хангалттай их усаар зайлах. Арьс гэмтсэн шинж илэрвэл эмнэлгийн тусламж авах. Залгисан үед: Эмнэлгийн тусламж яаралтай авах. | Хамаарагдах бүх дүрмийн дагуу хаягдлыг зайлуулна. Энэ бүтээгдэхүүнийг хатааж болохгүй. Хатаасан үед тус бүтээгдэхүүн нь исэлдүүлэгч болж хувирах магадлалтай бөгөөд EPA (40 CFR & 261)-ийн дагуу урвалд ордог хаягдал #D003 ангилалд хамаарагдана. Шингэн төлөвт байхад хаяж зайлуулах нь аюултайд тооцогддоггүй. Орон нутгийн хорт бодис хаяж зайлуулах байгууллагад хандах |
| 4 | Агааржуулагч үйлчлэл бүхий түүхий эд | Арьсанд хүрсэн үед цочрол өгч болзошгүй | Нүдэнд орсон үед: Нэн даруй дор хаяж 10 минутын турш зовхийг нээлттэй байлган усаар сайтар угаа. Эмнэлгийн тусламж ав. Арьсанд хүрсэн үед: Ус, савангаар арьсаа сайтар угаа. Цэврүү үүсэх буюу улайсан байвал эмнэлгийн тусламж ав. Тус бодисоор бохирдсон хувцсыг дахин хэрэглэхийн өмнө угаах буюу хими цэвэрлэгээнд цэвэрлүүлсэн байна. Амьсгалсан үед: Бодис тархсан газраас холд. Дулаан газар тайван байх. Амьсгалахад хэцүү байвал хүчилтөрөгчөөр дэмж. | Хаягдал зайлуулах арга: Тохирох шатаах зууханд шатаана. Улсын байгаль орчны хяналтын журмын дагуу хаягдлыг зайлуулна |

| № | Бодисын төрөл | Анхаарах зүйлс | Авах арга хэмжээ | Хаягдал зайлуулалтын үед авах арга хэмжээ |
|---|---------------|----------------|--|---|
| | | | Аманд ороход: Амаа усаар угаа. Бөөлжүүлэхийн тулд 2-3 аяга ус буюу сүү өг. Эмнэлгийн тусламж ав. | |

Хүснэгт 14. Химийн бодисыг хадгалах, ашиглах, асгарсан үед авах арга хэмжээ

| Бодисын төрөл | Галаас урьдчилан сэргийлэх, унтраах арга хэмжээ | Асгарч гоожсон үед авах арга хэмжээ |
|--|--|--|
| Усны орцыг багасгах төрлийн бодисууд Хөдөлгөөн багасгах болон гадаргууг бэхжүүлэгч үйлчлэл бүхий бодисууд | Бүхий л төрлийн гал унтраах хэрэгслийг (Усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий болон бусад) ашиглаж болно. Галын талбараас холдох ба галыг аюулгүй зайнаас унтраах, амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат өмсөх хэрэв бүтээгдэхүүн галд өртсөн бол усаар цацаж савыг хөргөнө. Хадгалах, ашиглах үед авах арга хэмжээ: Хэрэглэх үед: Ажлын орчин маш сайн агааржуулалтын системтэй байх. ХХАА-ны шаардлагын дагуу хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг өмссөн байх шаардлагатай. Хадгалах үед: Агаарын урсгалгүй, тусгай зориулалтын агааржуулах системтэй өрөөнд хадгалах. Хөлдөхөөс сэргийлж, нарны шууд тусах газар болон ноцох эх үүсвэрээс хол хадгалах | Асгарсан болон гоожсон шингэнийг тохирох саванд цуглуулан хийж аль болох хол байлгах. Бүтээгдэхүүн шалан дээр асгарсан бол нэн даруй цуглуулж авах. |
| Усны нэмэлт болон бэхжилтийг түргэсгэгч | Гал унтраах хэрэгсэл: Ус шүршигч буюу манан, хөөс, химийн хуурай нунтаг, нүүрстөрөгчийн диоксид Гал унтраах: Онцгой байдлын ажилтантай холбогдож аюул гарсан газрын байршил, нөхцөл байдлын талаар мэдээлэх. Амьсгалын аппарат бүхий, биеийг бүрэн халхалсан хамгаалалтын хувцас өмсөх. Боломжтой бүхий л аргаар асгарсан бодисыг усны шугам хоолой руу орохоос сэргийлэх. Галыг унтраах ба шаардлагатай хэсэгт хөргөлт бий болгохын тулд бүрэн ажиллагаатай шүршигч ашиглан усаар шүрших. Усан сан руу ус шүршигдэж орохоос сэргийлэх. Халсан байж болох сав руу ойртохгүй байх. Галд өртсөн савыг аюулгүй газраас усаар шүршин хөргөх. Хэрэв аюулгүй бол савыг галын бүсээс холдуулах. Хадгалах, ашиглах үед авах арга хэмжээ: | Бага хэмжээгээр асгарсан бол: Шатах бүхий л эх үүсгэврийг зайлуулах, асгарсан бүх бодисыг нэн даруй цэвэрлэх, уураар нь амьсгалах ба арьс, нүдэнд хүрэхээс сэргийлэх, хамгаалах хэрэгсэл ашиглан биед хүрэхээс сэргийлэх, элс, шороо, инертийн материал буюу вермикулитаар хучих буюу шингээх, цэвэрлэж авах. Хаягдлыг устгах зорилгоор тохирох, хаягласан саванд хийх. Их хэмжээгээр асгарсан бол: Ажлын талбарыг цэвэрлэж, салхины эсрэг талд шилжүүлэх, онцгой байдлын ажилтантай холбогдож аюул гарсан газрын байршил, нөхцөл байдлын талаар мэдээлэх, амьсгалын аппарат болон хамгаалалтын бээлий өмсөх, боломжтой бүхий л аргаар асгарсан бодисыг усны шугам хоолой руу орохоос сэргийлэх, тамхи татах, ил гал гаргах, ноцох эх үүсвэр байлгаж болохгүй, агааржуулалтыг нэмэгдүүлэх, аюулгүй хийж чадах бол асгаралтыг зогсоох, элс, шороо буюу вермикулитаар хучих, сэргээлт хийх боломжтой бүтээгдэхүүнийг дахин боловсруулахад зориулан хаягжуулсан саванд хийх. |

| Бодисын төрөл | Галаас урьдчилан сэргийлэх, унтраах арга хэмжээ | Асгарч гоожсон үед авах арга хэмжээ |
|---|---|--|
| | <p>Хэрэглэх үед: Хэвийн ажиллагааны нөхцөлд ерөнхий таталтын системийг ашиглах нь тохиромжтой. Гадна талын хаалт бүхий хамгаалалтын шил, химийн хамгаалалтын бээлий, жишээ нь ПВХ-он, элэгдэлд аюулгүй буюу аюулгүйн резинэн гутал өмсөх, хэт нөлөөллийн эрсдэл үүсвэл амьсгалын зөвшөөрөгдсөн аппаратыг зүүнэ.</p> <p>Хадгалах үед: Агуулах буюу битүүмжилсэн агуулахын байран дахь агааржуулалт хангалттай байх. Нитратууд, исэлдүүлэгч хүчлүүд зэрэг шаталтыг үүсгэж болох исэлдүүлэгч бодистой холилдохоос сэргийл.</p> | |
| <p>Бодисын төрөл Усны орцыг багасгах төрлийн бодисууд</p> | <p>Энгийн бус гал болон тэсрэлтийн аюул: Кальцийн нитритийн нэгдлийг DOT шингэн ашиглан туршсан. Исэлдүүлэгчийн туршилт (UN 34.4.2)-нд хамрагдаж исэлдүүлэгч биш болохыг тогтоосон. Гэвч, хатсан үедээ тус бодис нь исэлдүүлэгч болж хувирах бөгөөд шатамхай бодист исэлдүүлэгч болох аюултай. Үүнээс үүдэж гал түймэр гарвал нүүрстөрөгчийн давхар ислийн хөөсөөр унтраана.</p> <p>Хадгалах, ашиглах үед авах арга хэмжээ: Хэрэглэх үед: Нүдний хамгаалалтын шил зүүх, резинэн бээлий өмсөх. Хадгалах үед: Битүүмжлэл сайтай, сэрүүн, агааржуулалт бүхий нөхцөлд хадгалах, модон шалан дээр хадгалахгүй байх, чийг болон механик гэмтлээс хамгаалах, шатамхай, исэлдэх чанар өндөртэй бодисууд болон органик бодисуудтай хамт хадгалахаас зайлсхийх, халаагч эх үүсвэрүүдээс тусгаарлан хадгалах хэрэгтэй.</p> | <p>Санамсаргүй дууссан (гоожсон) алдсан тохиолдолд: Санамсаргүй алдагдсан хэсгийг цуглуулж, битүүмжлэх. Алдагдсан бүх хэсгийг битүүмжилж чадаагүй тохиолдолд Орон нутгийн хорт бодис хаяж зайлуулах байгууллагад илтгэх</p> |
| <p>Хөдөлгөөн багасгах болон гадаргууг бэхжүүлэгч үйлчлэл бүхий бодисууд</p> | <p>Гал унтраах хэрэгсэл: нүүрсхүчлийн хий, хуурай химийн бодис, хөөс, галын усан хор.</p> <p>Гал унтраах төхөөрөмж: Аливаа түгжигдмэл орон зайд эерэг даралттай амьсгалын аппарат зүү</p> <p>Хадгалах, ашиглах үед авах арга хэмжээ: Хэрэглэх үед: Нүд, арьс, хувцсанд хүргэхээс зайлсхий. Уур, утаагаар нь амьсгалахаас зайлсхий. Бодистой харьцсаны дараа гар, нүүрээ сайтар угаа. Онцгой үед ашиглах шүршүүр, нүд угаах төхөөрөмж бэлэн байх ёстой. Ашиглаагүй үедээ савнуудыг сайтар тагласан байх. Хадгалах үед: Сэрүүн, хуурай, агааржуулалт сайтай, нарны шууд тусгалаас хол хадгалбал зохино. Хадгалах тохиромжтой материал нь шил, полиэтилен, зэвэрдэггүй ган юм. Хөнгөнцагаан, хөнгөнцагааны хайлш, зэс, зэсийн хайлш, зөөлөн ган, тугалган саванд бүү хадгал.</p> | <p>Асгарсан үед: Тохирох хамгаалах хувцас, хэрэгсэл өмс. Бодисыг суваг болон усны эх үүсвэр рүү орохоос сэргийлэхийг хичээ. Хэрэв энэхүү бодис усны эх үүсвэр буюу урсгуур сувгийн хоолойд асгарч орсон, эсвэл хөрс, ургамлыг бохирдуулсан бол холбогдох эрх бүхий албанд мэдэгд. Шингээгч материалд (хуурай элс, шороо, үртэс, даавуу гэх мэт) шингээж ав. Устгах зориулалтаар хаягжуулсан хаягдлын саванд хадгал</p> |

9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал мян.₮ | Тоо хэмжээ | Нийт зардал мян.₮ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|------------------------|--|---|----------------|--------------------------------|------------|-------------------|------------------------------|---|
| 1 | Ахуйн болон үйлдвэрийн | Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Төслийн талбай | - | - | - | - | 2024 | ХХТ хууль |
| 2 | Ахуйн | Хатуу хог хаягдлаар орчныг бохирдуулахгүй байх, хатуу хог хаягдлыг нэг цэгт бөөгнөрүүлж, УБ нэгдсэн хогийн цэг рүү тээвэрлэх | Төслийн талбай | удаа | Үйл ажиллагааны зардалд орсон. | | | 2024 | ХХТ хууль, НИТХ-ын 2013 оны “Хог тээврийн тариф батлах тухай” 12/45 тогтоол |
| 3 | | Хог хаягдлыг эргүүлэн ашиглах | Төслийн талбай | - | - | - | - | 2024 он | ХХТ хууль |
| 4 | | Агуулахын талбайд ахуйн ангилдаг хогийн сав байршуулах | Төслийн талбай | ш | 3,500.0 | 1 | 3,500.0 | 2024 он | |
| 5 | | Ил гал түлэх байдлаар хог хаягдлыг шатаахгүй. | Төслийн талбай | - | - | - | - | 2024 он | |
| 6 | | Аюултай | Агаарт шатах тослох материалын ууршилт гаргахгүй байх, техникийн засвар үйлчилгээний чанарт байнга хяналт тавьж, автомашины жилийн улсын үзлэгт хамруулах | Төслийн талбай | машин | ҮАЗ | - | ҮАЗ | 2024 он Жилд 1 удаа |
| 7 | | “Эх үүсвэрээс гарах аюултай хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, тогтоосон хугацаанд тайлагнах | Төслийн талбай | - | - | 1 | 1,200.0 | 2024 он | ХХТ хууль |
| 8 | Шингэн | Үйлдвэр болон лаборатори, орчны цэвэрлэгээнээс гарах шингэн хог хаягдал, саарал усыг дахин ашиглах. | Төслийн талбай | удаа | Үйл ажиллагааны зардалд орсон. | | | 2024 он | |
| 9 | Нийт | Ашиглагдсан эд материалын жин, эзлэхүүнийг бүртгэх | Төслийн талбай | - | - | | | - | Сика группийн “Тогтвортой байдлыг |
| 9 | | Дахин боловсруулагдсан материалын ашиглалт | Төслийн талбай | - | - | | | 2024 он | |

| | | | | | | | |
|---|---|---|----------------|---|---------|---------|----------------------------|
| 10 | | Нийт хог хаягдлын хэмжээ, төрөл ба зайлуулж буй аргыг бүртгэх, хянах | Төслийн талбай | - | - | 2024 он | тайлагнах удирдамж” - 2020 |
| 11 | Ахуйн болон аюултай хог хаягдал устгуулах | Хог хаягдлыг дахин боловсруулах, аюултай хог хаягдал, сав баглаа боодлыг устгах, боловсруулах эрх бүхий үндэсний компаниудтай хамтран ажиллах | Төслийн талбай | - | 1,200.0 | 2024 | ХХТ хууль |
| Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал 4,700.0 төгрөг | | | | | | | |

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав. ОХШХ нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. Хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан арга зүй, стандартын дагуу шинжлүүлнэ.

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналт шинжилгээ хийх байршил | Хугацаа ба давтамж | Шаардагдах зардал (мян.төгрөг) | Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд |
|----------------------------|---|--------------------------------|-------------------------------------|--------------------------------|---|
| 1. Агаарын чанар | | | | | |
| 1.1 | Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх | Агуулах дотороо | Агаарын найрлага: жил бүрийн 6 сард | 200.0 | MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ |
| 1.2 | Дуу шуугиан, чичиргээ | | Жилд бүрийн 6 сард | 150.0 | |
| 2. Хөрсний бохирдол | | | | | |
| 2.1 | Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, | Төслийн талбайд 2 цэг сонгох / | Жил бүрийн 6 сард | 800.0 | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, |

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналт шинжилгээ хийх байршил | Хугацаа ба давтамж | Шаардагдах зардал (мян.төгрөг) | Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд |
|--|--|-------------------------------|--------------------|--------------------------------|---|
| | шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр | | | | MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| 3. Усны орчин | | | | | |
| 3.1 | Унд, ахуйн усны бүрэн шинжилгээ | Ажилчдын унд, ахуйн ус | Жилд бүрийн 6 сард | 250.0 | MNS 4943:2011 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус Ерөнхий шаардлага |
| Орчны хяналт шинжилгээний хотөлборийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2024 оны нийт зардлын дүн | | | | 1,400.0 төгрөг | |

11. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | Хариуцсан албан тушаалтан |
|---------------------|---|-------------------------|---------------------|---------------------------|
| 1 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах | Дотоод зардлаар | 2024 | Сика Монголиа ХХК |
| 2 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн биелэлтийн тайланг боловсруулж дүгнүүлэх | Дотоод зардлаар | 2024 | Сика Монголиа ХХК |
| 3 | Байгаль орчны нийцлийн аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэх | ҮАЗ – гэрээний дагуу | 2025 | Сика Монголиа ХХК |
| Нийт зардал: | | 300.0 төгрөг | | |

12. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 18. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

| № | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Хугацаа | Тайлагнах зардал, мян.₮ | Хариуцан байгуулах ажилтан | Зохион байгуулах газар |
|--|---|--|---|----------------------|-------------------------|----------------------------|------------------------|
| 1 | Нийслэлийн байгаль орчны газар | Биелэлтийн тайлан хэлэлцүүлэх, газар дээрх үзлэг | БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу | 11.01 дотор | 400.0 | БОХА | УБ хот |
| 2 | БОАЖЯ | Тухайн жилийн Байгаль орчны менежмент төлөвлөгөө | | Дараа жилийн 01 сард | 200.0 | БОХА | УБ хот |
| Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний нийт зардал 600.0 төгрөг | | | | | | | |

13. 2022 онд хийгдсэн байгаль орчны аудитын зөвлөмжид тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө

“БОАД” ХХК болон “Сика Монголиа” ХХК-ийн хооронд байгуулсан 17/01 дугаартай “Байгаль орчны аудитын ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу 2022 оны 05 сарын 15 өдрөөс эхлэн 2022 оны 08 сарын 08-ны хооронд “Сика Монголиа” ХХК-ийн Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Бетоны нэмэлтийн үйлдвэр, агуулах” төслийн үйл ажиллагаанд “БОАД” ХХК болон “Байгаль орчин консалтинг” ХХК-ийн 4 хүний бүрэлдэхүүнтэй аудитын баг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 101 зүйлийн дагуу БОАЖСайдын 2019 оны А-809 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны аудит хийх эрх олгох журам”, “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал” болон Компанийн өөрийн боловсруулсан “Эрсдэлд суурилсан аудитын нарийвчилсан арга зүй”-г мөрдлөг болгон нийт 110 шалгуур үзүүлэлтээр байгаль орчны нийцлийн аудитыг гүйцэтгэсэн. Уг төслийн үйл ажиллагааны эрсдэлийн түвшний үр дүнд үндэслэн гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зөвлөмжийг бидэнд өгсөн. Энэхүү зөвлөмжийн дагуу шинэ агуулахын байршилд төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг дараах байдлаар боловсрууллаа.

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | 3-р улирал | 4-р улирал | Хариуцсан албан тушаалтан |
|---|--|-------------------------|------------|------------|---------------------------|
| 1 | Байгалийн болон хүний хүчин зүйл техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ дахин хийж, сайжруулах ба эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, төлөвлөгөөг шинэчлэх, байгалийн гамшиг, үйлдвэр, тээврийн ослын үед гарч болзошгүй химийн хорт бодисын алдагдлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг нь арилгах замаар амьдрах орчны аюулгүй байдлыг хангах байдлыг нэмэгдүүлэх, сайжруулах. | Дотоод зардлаар | | | БОМ, Нийт ажилчид |

| | | | | | |
|---|--|-----------------|--|--|-------------|
| 2 | Химийн хорт болон аюултай бодисыг техникийн болон аюулгүйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэж буйг бататгах бөгөөд уг тээврийн хэрэгсэлд анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарын тухай санамж байрлуулж, тээвэрлэлт, ачилтын явцыг баталгаажуулах, зааварчилгаа өгөх хэлбэр, нотолгоо баримтжуулалтыг сайжруулах | Дотоод зардлаар | | | БОМ & ХАБЭА |
| 3 | Тээвэрлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа тухайн бодисын монгол хэл дээрх хор, аюулгүй байдлын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж гарын үсэг зуруулах ба дотоод журамд заасан хугацаанд хадгалах. | Дотоод зардлаар | | | БОМ & ХАБЭА |
| 4 | 2022 онуудын аудитын үр дүнг -ээс гарсан зөвлөмж, Гамшгийн эрсдэлийн үнэлгээнээс гарсан зөвлөмж, Химийн ослын эрсдэлийн үнэлгээнээс гарсан зөвлөмжийг тус тус үндэслэн шинэ агуулахын байршилд тусгайлсан эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг баримтжуулах | Дотоод зардлаар | | | БОМ & ХАБЭА |

**“СИКА МОНГОЛИА” ХХК-ийн “Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох, ашиглах, хадгалах агуулах”
төслийн 2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ын нийт зардал**

| № | БОМТ-2024 Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөвлөсөн зардал /төгрөг/ |
|--------------------|--|-------------------------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө | 1,200,000.0 |
| 2 | Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 420,000.0 |
| 3 | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | -- |
| 4 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2,650,000.0 |
| 5 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 4,700,000.0 |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 1,400,000.0 |
| 7 | Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө | 300,000.0 |
| 8 | Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | 600,000.0 |
| 9 | 2022 оны аудитын үр дүнг -ээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө | Дотоод зардал |
| НИЙТ ЗАРДАЛ | | 11,270,000.0 төгрөг |